



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар

605

Улаанбаатар хот

Шалган зааварчлах ажлын мөрөөр авах  
зарим арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаанд хийсэн мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, шалган зааварчлах ажлын дүнгээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.

2.Шалган зааварчлах ажлын тайланд дурдсан дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, өмчийн харилцааны чиглэлээр батлан гаргасан зарим тогтоол, шийдвэрийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэх, шаардлагатай тохиолдолд хүчингүй болгох арга хэмжээ авахыг Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд зөвлөсүгэй.

3.Говь-Алтай аймгийн Засаг дарга Г.Чинбат, Говь-Алтай аймгийн Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

3.1.Шалган зааварчлах ажлын хүрээнд илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах асуудлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;

3.2.Говь-Алтай аймгийн өмчийн харилцааны чиглэлээр мөрдөж буй журам, гэрээний загвар, маягт, аргачлалыг хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэн боловсруулж, эрх бүхий этгээдээр батлуулах;

3.3.Хийж гүйцэтгэсэн ажлын тайланг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (Н.Ганболд) -т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133302643

28-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2024 оны 4 сарын 25-ны өдрийн  
60 дугаар тогтоолын хавсралт

**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДЛЫГ  
АРИЛГАХ АРГА ХЭМЖЭЭ, ЗӨВЛӨМЖ**

Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал (өмчлөгч), Засаг дарга, Орон нутгийн өмчийн газарт өмчийн харилцааны чиглэлээр дараах дүгнэлт, зөвлөмжийг өгч байна:

1. Орон нутгийн өмчийн газрын чадавхийг сайжруулж, албан хаагчдыг компанийн засаглал, хяналт шалгалт, хууль эрх зүйн, хяналт шинжилгээ, санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр сургалтад хамруулж, мэдлэг чадварыг дээшлүүлэх;

2. Албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн 527 дугаар тогтоолоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар батлахаар зохицуулсан байсныг нэмэлт өөрчлөлтийн дагуу эрх бүхий албан тушаалтнаар батлуулж Төрийн албаны зөвлөл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлэх ёстой боловч ирүүлээгүй тул хууль, тогтоомжид нийцүүлэх;

3. ОНӨГ-ын албан хаагч нарын хувийн хэргийн бүрдлийг хангах, анкет, холбогдох мэдээллийг иж бүрэн байлгах ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлсэн үнэлгээний хуудас, гүйцэтгэлийн тайланг хувийн хэрэгт оруулж баяжилтыг цаг тухай бүр хийж, хувийн хэргийн эмх цэгц, стандартыг хангах;

4. Төрийн албаны ерөнхий шалгалт өгч томилогдоогүй төрийн захиргааны 2 албан хаагч ажиллаж байгаа тул хууль, тогтоомжид нийцсэн томилгоо хийж байх, төрийн захиргааны албан тушаалын орон тоон дээр ажиллаж байгаа албан хаагчийг ТҮ-ний албан хаагчийн цалингийн шатлалаар цалинжуулан ажиллаж байгаа, мэргэжлийн индекс таараагүй байгаа зэрэг зөрчлийг арилгах;

5. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд зорилт, арга хэмжээ болон шалгуур үзүүлэлтийг оновчтой илэрхийлж байх (хэмжигдэхүйц, биелэгдэхүйц г.м.), мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилгыг тодорхой төлөвлөж байх;

6. ОНӨГ-ын албан бичиг, архив, тушаал, шийдвэрийн боловсруулалт, хадгалалт хамгаалалт, бүртгэл, хяналтад Монгол Улсын Засгийн газрын "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам" батлах тухай 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 246 дугаар тогтоолыг дагаж мөрдөх;

7. АИТХ-ын 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, данснаас хасах, тайлагнах журам"-ын 6 дугаар бүлэг 6.1-6.9 хүртэл хөрөнгө худалдахтай холбоотой зохицуулалт нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн заалтыг хуулж оруулсан (6.1, 6.8), гадагшаа хандсан зохицуулалт (журам батлах 6.5)-ыг оруулсан байх тул уг бүлгийг хүчингүй болгох, эсхүл хуульд нийцүүлэн өөрчлөлт оруулах;

8. АИТХ-ын 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 53 дугаар тогтоолоор Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх, гэрээ байгуулахтай холбоотой харилцааг зохицуулахдаа "гэрээний сунгалтын загвар"-ыг орхигдуулсан тул нэмж батлах,

гэрээний зүйлийн талаар илүү тодорхой мэдээлэл оруулах асуудлыг судлан шийдвэрлэх;

9. АИТХ-ын 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 54 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Орон нутгийн хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй хөрөнгийг худалдах, дуудлагын худалдааг зохион байгуулах журам” баталсан нь АИТХ нийтээр мөрдөх шинжтэй ийм журам батлах эрхгүй, Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлээгүй зэрэг үндэслэлээр уг журмыг үндэслэн гарсан шийдвэрүүд эрх зүйн чадамжгүй болох эрсдэлтэй тул хүчингүй болгох, өөрчлөн хуульд нийцүүлэх. (Мөн энэхүү журамд Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль зэрэг хуулиар зохицуулагдсан харилцааг оруулсан, гэрээгээр зохицуулах боломжтой харилцааг оруулсан байгааг анхаарах);

10. АИТХ-ын 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 55 дугаар тогтоолоор баталсан “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам”-д орон нутгийн өмчит байгууллагын эзэмшиж, ашиглаж буй газар болон үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэлтэй холбоотой асуудлыг орхигдуулсныг нэмж тусгах;

11. АИТХ-ын 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 56 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар “Орон нутгийн өмчийг түрээслүүлэх журам” баталсан нь АИТХ нийтээр мөрдөх шинжтэй ийм журам батлах эрхгүй, Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлээгүй зэрэг үндэслэлээр хүчингүй болгох. (Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49, 50, 51 дүгээр тогтоолоос жишиглэн түрээсийн харилцааны зохицуулалтыг илүү ойлгомжтой болгож, зохицуулалтгүй харилцаа үүсгэхгүй байхад анхаарч ажиллах);

12. Шүүхэд үүссэн хэрэг маргаан бүрийг хавтаст хэрэг болгож стандартын дагуу бүрдүүлэх, архивлах болон хэрэг маргааны танилцуулга файл үүсгэж нэгтгэн цэгцлэх, Орон нутгийн өмчийн газрын дагаж мөрдөж буй дүрэм, журам, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэгтгэн эмхэтгэж үйл ажиллагаандаа байнга ашиглах;

13. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 271 дүгээр тогтоолоор баталсан журмын 7-д заасан “үнэ шинэчлэн тогтоох”-той холбогдсон зохицуулалт (Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/229 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 10-Үндсэн хөрөнгө, (ж)...)-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, төсвийн байгууллагад мөрдөж, холбогдох шийдвэрийг цаг тухайд нь гаргаж байх;

14. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэх асуудалд гарах шийдвэрийн төсөл, танилцуулгыг бэлтгэж “боловсруулсан”, “хянасан”, “танилцсан”, хурлаар оруулахыг зөвшөөрсөн албан тушаалтны нэр, гарын үсэг, огноо бүхий хяналтын хуудас, холбогдох баримтын бүрдлийг хангах, хурлын дэг, асуудал шийдвэрлүүлэх дараалал, хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, өмчийн харилцааны асуудлаар шийдвэр гаргуулахын өмнө тухайн хөрөнгийг худалдах, актлах, шилжүүлэх, үнэлэх болсон шалтгаан, үндэслэлийг нарийвчлан хянаж, тэмдэглэл хөтлөх, шийдвэрийн хавсралтад шаардлагатай мэдээллийг бүрэн тусгах, хөрөнгө шилжүүлэх болон худалдан авсан этгээдэд хүлээлгэн өгсөн акт үйлдэж байх;

15. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэх асуудлыг тогтоолын төсөл, батлагдсан тогтоолын төсөлд хөрөнгийн зохицуулалтыг хариуцан гүйцэтгэх этгээд (ӨХБЗ, Гүйцэтгэх захирал, ОНӨГ гэх мэт)-ийг зааж, хийх ажил,

биелэлтийг тайлагнах хугацааг зааж биелэлтийг тайлагнах, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах зохицуулалтыг бий болгох;

16. Аймгийн ОНӨГ-ын бүтэц орон тоонд хяналт шалгалт хариуцсан мэргэжилтний орон тоо батлагдсан тул Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор батлагдсан ОНӨГ-ын холбогдох ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтын дагуу хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжил арга зүйн зөвлөмжийн дагуу газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд энэ талаар зорилт арга хэмжээг төлөвлөн тусгаж хэрэгжүүлэх, өмч эзэмшлийн гэрээ байгуулах, дүгнэх замаар орон нутгийн өмчид бүртгэлээр хяналт тавих, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, компанид хянан шалгалт хийх, энэ ажилд зарцуулах зардлыг төсөвт тусган хэрэгжих боломжоор хангах ажлыг зохион байгуулах;

17. Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” 340 дүгээр тогтоолын 1-д “...Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр зохих хууль журмын дагуу хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тус тус үүрэг болгосугай...” гэж заасан болно. Иймээс төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, бизнесийн үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах зорилгоор орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжийг судлан хэрэгжүүлэх;

18. Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д “...Өмчлөгч буюу түүнээс эрх олгогдсон этгээд нь өмчлөх эрхийнхээ тодорхой хэсгийг ажилтнаар дамжуулан хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлагын түвшний ажил үүрэг гүйцэтгүүлэх зорилгоор тухайн ажилтантай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулж болно...” гэж заасан заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 84 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ыг удирдлага болгон “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах, “Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирал, гүйцэтгэх удирдлагатай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дүрэм зэргийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулж, мөрдүүлэх;

19. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангах;

20. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, Гүйцэтгэх удирдлага болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компанийн санхүүгийн тайлан тэнцэл, аудитын дүгнэлт, зөвлөмжийг авч хэлэлцэн зохион байгуулалтын бүтцийг оновчтой болгох, орлогыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, Улсын төсөв, гадаад дотоодын хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр, хандив зээл тусламжийн эх үүсвэрээр бий болсон

хөрөнгийн зориулалт, зээлийн эргэн төлөлт, тэдгээрийг нягтлан бодох бүртгэлд тусгах талаар тодорхой арга хэмжээ авах;

21. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, Улсын төсөвт үйлдвэрийн газруудын сул орон тоог нөхөх ажлыг Засгийн газрын 2023 оны 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам”-ын дагуу зохион байгуулж байх;

22. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 46 дугаар тогтоолоор “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г тус тус баталсан. Тус тогтоолоор төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгжилтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Авлигатай тэмцэх газарт тайлагнаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлаг, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага болон бусад эрх бүхий байгууллагуудад даалгасан тул хэрэгжүүлэх арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан ажиллах;

23. Компанийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг тус тус үйл ажиллагаандаа чанд мөрдөн ажиллах чиглэлийг холбогдох албан тушаалтан болон орон нутгийн өмчит компани, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагуудад өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

24. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасны дагуу “Хувьчлах орон нутгийн эд хөрөнгийн жагсаалт”-ыг батлахдаа заавал Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөж байх;

25. ОНӨГ-ын албан ёсны вебсайт, цахим хуудас дахь мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг хангаж ажиллах.